

**МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД СУУХ ЭЛЧИН САЙДЫГ ТОМИЛОХ
АСУУДЛААР ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Бүгд Найрамдах Польш Улс болон европын улс орнуудтай экспорт, импорт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажиллах, Гадаад харилцааны яам мэргэшсэн албан хаагчийг дипломат албанд томилох, улс төрийн томилгоо хийх асуудал дээр ямар байр суурьтай ажиллаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, Бүгд Найрамдах Польш Улсын хөдөө, аж ахуйн салбарыг өөрийн улстай холбох, боомтын асуудалд анхаарах, уламжлалт анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа, аюулгүй байдал, гадаад орчны асуудалд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нэр дэвшигчийг дэмжиж байгаа бөгөөд цаашид ийм мэргэжлийн хүнээр Элчин сайдын яамны тэргүүнийг томилох нь зүйтэй талаар, манай улсын иргэд гадаадын хэдэн улсад визгүй зорчиж байгаа тухай, цаашид энэ тоог нэмэгдүүлэхэд хэрхэн анхаарч байгаа талаар нэр дэвшигч болон Гадаад харилцааны яамнаас асуулт асууж, хариулт авсан.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн мэргэжлийн болон төрийн албаны дадлага туршлагатай, хэлний өндөр мэдлэгтэй, дипломат албаны шаардлагыг хангасан хүнийг энэ албанд томилоход анхаарч ажиллах талаар үг хэлсэн.


Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Наваан-Юндэнгийн Оюундарийг Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН